



ДУНДГОВЬ АЙМГИЙН
САЙНЦАГААН СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2021 оны 12 сарын 02 өдөр

Дугаар 61

Мандалговь

Үндсэн хөрөнгө данснаас хасах
санал уламжлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3 дахь хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 30 дугаар тогтоолоор батлагдсан Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журмын 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсгийг тус тус үндэслэн сумын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн саналыг хэлэлцээд сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь :

1. Сумын ЗДТГ-ын үндсэн хөрөнгийн автотээврийн хэрэгслийн дансанд бүртгэлтэй 25,000,000 төгрөгийн балансийн үнэтэй, үлдэгдэл өртөггүй УАЗ-ПУРГОН автомашиныг актлуулж, данснаас хасах саналыг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдэд уламжилсугай.

2. Тус үндсэн хөрөнгийн холбогдох бичиг баримтын бүрдлийг хангаж аймгийн ИТХурлын Тэргүүлэгчдэд хүргүүлэхийг ЗДТГ-ын дарга (Ц.Лхагвасүрэн) даалгасугай.

ДАРГА



Т.БАТЖАРГАЛ